



**ХӨРШИЙН ХЯНАЛТЫН  
БҮЛГИЙН  
ГАРЫН АВЛАГА**

## ГАРЧИГ

1.	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол.....	3
2.	Хөршийн хяналтын хөтөлбөр.....	4
3.	Хөршийн хяналтын хэрэгжүүлэх журам.....	10
4.	Итгэлцлийн гэрээний загвар .....	18
5.	Аргачилсан зөвлөмж.....	23
6.	“Хөршийн хяналт” нэгдсэн систем.....	26

## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр      Дугаар 126      Улаанбаатар хот

### **Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.9, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 13.2.2, 13.2.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.2, 5.1.4, 5.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01/2139 албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэр, гудамж талбай, байр, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвх, санаачилгад суурилсан амгалан тайван байдлын тогтолцоог бүрдүүлэх “Хөршийн хяналт” хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Нийслэлд хөршийн хяналт хөтөлбөр батлагдсантай холбогдуулан “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолоор батлагдсан журмын дагуу хөршийн хяналтынхөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, эхний ээлжид шаардагдах зардлыг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлж, цаашид хөтөлбөрийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн нийслэлийн төсөвт тусгуулах, батлагдсанаас хойших хэрэгжилтийн тайланг 2015 оны IV улиралд багтаан танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Б.Энхболд/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАТТУЛГА

## ХӨРШИЙН ХЯНАЛТ ХӨТӨЛБӨР

### Нэг. Хөтөлбөрийн зорилго

Нийслэлийн иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

### Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага, үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрүүл, аюулгүй, амар тайван орчинд ажиллаж, амьдрах бүрдүүлэхэд иргэд, оршин суугчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлага байгааг дараах үндэслэлээр тодорхойлж байна.

#### Үүнд:

1. Орон нутгаас нийслэл хотод шилжин ирэгсдийн тоо нэмэгдэж, хүн амын механик өсөлт, хэт төвлөрөл бий болж, хөрш зэргэлдээ айл өрх, иргэд бие биенээ таньж мэдэхгүйгээс найрсаг дулаан харилцаа холбоо алдагдсан;

2. Гудамж талбай, гэр, орон сууц, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж байгаа;

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4 дүгээр бүлэг 'Аюулгүй, амгалан Улаанбаатар буюу хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах' бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;

Хөтөлбөрт нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, засаг захиргааны анхан шатны нэгж 30 хорооны 4000 орчим иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 1200 орчим иргэдээс цахим хэлбэрээр санал асуулга авч, тусгасан.

Гурав. Хүрэх үр дүн

1. Ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил буурна.

2. Аюулгүй амьдрах нөхцөл боломж бүрдэнэ.

3. Нийслэлийн иргэд, оршин суугчдын нийгмийн хариуцлага нэмэгдэнэ.

4. Айл хөршийн нэгдлийг бий болгож тэдэнд өөрсдөөрөө бахархах сэтгэл төрүүлнэ.

5. Холбогдох байгууллагуудыг шуурхай мэдээллээр хангах боломж бүрдэнэ.

6. Иргэд, оршин суугчдаас ирүүлэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл нэмэгдэнэ.

7. Цагдаагийн байгууллагад идэвхтэй дэмжлэг үзүүлэх ухамсар төлөвшинэ,

8. Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.

9. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, оршин суугчдын оролцоо дэмжлэгийг үнэлж, дүгнэдэг, урамшуулах нөхцөл бүрдэнэ..

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хугацаа

Хөтөлбөр нь нийслэлийн иргэд оршин суугчид, төрийн болон төрийн бус байгууллага, хамарна. Хөтөлбөрийг дараах үе шатаар хэрэгжүүлнэ. Үүнд:

I буюу бэлтгэл үе шат 2015 он дуустал;

II буюу хэрэгжүүлэх үе шат 2016 - 2020 он;

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим

Иргэд, оршин суугчдын сайн дурын идэвхисанаачлага, итгэлцэлд түшиглэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, хувь хүний нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах зарчмыг баримтална.

## Зургаа. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажиллана.

*Зорилт 1.* Хөршийн хяналтын бүлэг-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.1. “Хөршийн хяналт” хөтөлбөр, төлөвлөгөө, “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг боловсруулан батлуулах;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.2. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачилсан зөвлөмж боловсруулж, хүргүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.3. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн ажлыг үнэлэх, урамшуулах шалгуур, үзүүлэлтийг боловсруулж, батлуулах;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.4. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүдийн мэдээ, мэдээлэл дамжуулах сүлжээ бий болгох;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.5. “Хөршийн хяналтын бүлэг”, Сууц өмчлөгчдийн холбоо, Засаг дарга, хорооны цагдаагийн хэсгийн байцаагч нарын харилцан, хамтран ажиллах итгэлцлийн гэрээний загварыг боловсруулах;

*Зорилт 2.* “Хөршийн хяналтын бүлэг”-ийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагаа, ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, уулзалт зохион байгуулах;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.2. Нутаг дэвсгэрийн сууршилийн бүсийн онцлогт тохируулан орон сууцны орц, гудамжаараа сайн дураараа нэгдэн хөршийн хяналтын бүлэг байгуулах үйл ажиллагааг дэмжих;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.3. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүдэд сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.4. “Хөршийн хяналт бүлэг”-ийн гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.5. Гадаад орнуудад хэрэгжүүлж байгаа “Хөршийн хяналт”-ийн чиглэлээр хэрэгжүүлсэн тэргүүн туршлагыг судалж, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.6. Жил бүрийн 8 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Бямба гаригт “Хөршийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.7. Тусгай мэргэжилтэй /түлхүүр олшруулдаг, сейф, хаалга онгойлгодог/ иргэдийн бүртгэл, судалгаа гаргаж, мэргэжил, ёс зүйн тавигдах шаардлагыг тодорхойлж, нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллахад дэмжлэг үзүүлэх;

*Зорилт 3.*

“Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүдээс гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. “Хөршийн хяналтын бүлэг”-ээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллагад мэдээлэх, хүргэх, шийдвэрлэх үйл ажиллагааг уялдуулах үүрэг бүхий төрийн бус байгууллагыг байгуулахад дэмжлэг үзүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааны хүрээнд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн тэмдэг, тэмдэглэл хийх, хяналтын бүсийн заагийг тогтооход мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.3. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүдэд нийтийн болон хувийн эзэмшлийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, хяналт тавих арга зүйд сургах;

*Зорилт 4.*

“Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд техник, технологийн ололтыг ашиглана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гудамж, орон сууцны орц, нийтийн эзэмшлийн талбайг орон нутгийн төсвийн хөрөнгөөр камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.2. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг уялдуулах үүрэг бүхий төрийн бус байгууллагын цахим мэдээллийн нэгдсэн бааз, программ хангамжийг бий болгож, ашиглах журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.3. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд харилцаа, холбооны техник, технологийг ашиглаж, мэдээллийн шуурхай байдлыг хангах;

*Зорилт 5.*

Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдэлийн үнэлгээ, судалгаа хийнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдэлийг тодорхойлох судалгааг холбогдох байгууллагын статистик мэдээлэл дээр үндэслэн хийх;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.2. Аюулгүй байдлын орчны эрсдэлийн байдалд дүн шинжилгээ хийж, иргэд, оршин суугчдыг хамруулсан уулзалт, ярилцлага, санал асуулгыг тогтмол зохион байгуулах;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.3. Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

*Зорилт 6.*

Иргэд, оршин суугчдын амьдарч буй орчинд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын дэмжлэг, туслалцааг авна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1. Иргэд, оршин суугчдын амьдарч буй орчинд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ашиг сонирхлыг тодорхойлох судалгаа хийх;



Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.2. Иргэд, оршин суугч, байгууллагуудын ашиг сонирхолд тулгуурлан хамтын ажиллагааны чиглэл, тэдгээрийн оролцоог тодорхойлж, тохиролцох;

Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.3. “Хөршийн хяналтын бүлэг” болон даатгалын байгууллага хоорондын харилцан ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал;

Олон улсын байгууллагын хандив, тусламж;

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

Иргэдийн өөрсдийн хандив, хуримтлал;

Бусад эх үүсвэр;

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж дүгнэнэ. Үүнд:

1. Гэмт хэрэг, зөрчлийн бууралт;

2. Засаг захиргааны анхан шатны нэгжид хамтын оролцоотой “Хөршийн хяналтын бүлэг”-т иргэд хамрагдсан байдал;

3. Иргэд амьдарч буй орчноо “аюулгүй” гэж үнэлсэн байдал;

4. Иргэдийн дунд явуулсан санал асуулгын дүн;

## ХӨРШИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмаар иргэн, оршин суугчид өөр хоорондоо сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, өөрсдийн амьдарч буй орчиндоо амар тайван, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна.

2. Хөршийн хяналтыг хэрэгжүүлэгч иргэн, оршин суугч нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Зорилго

2.1. Нийслэлийн иргэд, оршин суугчдын идэвхи, санаачлагад суурилсан хөршийн хяналтыг бий болгож, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Энэхүү журмыг Нийслэл хотод оршин суугч иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дагаж мөрдөнө.

Дөрөв. Нэр томъёоны тайлбар

“Хөршийн хяналт” иргэд өөрсдийн амьдарч буй нутаг дэвсгэрт аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

“Хөршийн хяналтын бүлэг”-Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллаж байгаа иргэдийн сайн дурын нэгдлийг ойлгоно.

Тав. Хөршийн хяналтын үйл ажиллагааны хэлбэр

5.1. Орон сууц болон газар эзэмшигч /гэр хороолол/ иргэд тухайн суурьшлийн бүсийн онцлогт тохируулан, сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж ажиллана.

Зургаа. Хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааны чиглэл

6.1. Гэр хороолол, орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орц хонгилд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах;

6.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөршийн хяналтыг хэрэгжүүлэхэд бүх шатны Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах;

6.3. Оршин суугчид өөрсдийн амьдарч буй орчны эрүүл, аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн зохион байгуулах;

6.4. Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оршин суугчдын дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулах;

6.5. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;

6.6. Иргэд, оршин суугчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах

6.7. Иргэд, оршин суугчдад холбогдох шаардлагатай мэдээ, мэдээлэл дамжуулах сүлжээ бий болгох;

6.8. Эд хөрөнгийн тэмдэг, тэмдэглэгээ хийх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөршийн хяналтын бүсийн заагийг тогтоох;

6.9. Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдэлийн үнэлгээ, судалгаа хийх;

Долоо. “Хөршийн хяналт”-ын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

7.1. “Хөршийн хяналт”-ын үйл ажиллагааг дараах байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. Үүнд:

7.1.1. Нийслэл - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Засаг дарга, Улаанбаатар хотын цагдаагийн газар

7.1.2. Дүүрэг - дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг дарга, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага

7.1.3. Хороо - Иргэдийн Нийтийн хурал, Засаг дарга, хороо хариуцсан хэсгийн байцаагч тус тус мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

7.2. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүн иргэд, оршин суугчдын саналаар бүлгийн ахлагчийг сонгоно.

7.3. Хорооны иргэдийн нийтийн хурал, Засаг дарга, хорооны хэсгийн байцаагч нь “Хөршийн хяналтын бүлэг”-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, сар бүр бүлгийн ахлагч нарын хуралдааныг, улирал, хагас, бүтэн жилээр бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, үнэлэлт өгнө.

7.4. “Хөршийн хяналтын бүлэг”-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хорооны иргэдийн нийтийн хурлаар хагас жил тутам олон нийтэд нээлттэй тайлагнаж хэлэлцүүлнэ.

7.5 Иргэдийн нээлттэй хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг бүлгийн жилийн хийх ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

Найм. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн эрх, үүрэг

8.1. “Хөршийн хяналтын бүлэг” нь иргэдийн харилцан итгэлцлийн үндсэн дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулна.

8.2. Гишүүд, оршин суугч иргэдтэй уулзалт зохион байгуулж, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэл баримтална.

8.3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчтай тогтмол уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцон хамтарч ажиллана.

8.4. Хорооны Засаг дарга, Сууц өмчлөгчдийн холбоо, / ГӨХ/, хороо хариуцсан хэсгийн байцаагч, оршин суугчидтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, хууль бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр ажиллана.

8.5. Бүлгийн гишүүдийн утасны жагсаалтыг гаргаж, гишүүдэд анхааруулах, мэдээлэл түгээх сүлжээг бий болгож, холбогдох байгууллага /цагдаа, онцгой байдал, эмнэлэг/-ыг мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

8.6. Болзошгүй гамшиг, осол, эрсдэлийн үед хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, гишүүдэд сургалт зохион байгуулж, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлнэ.

8.7. Хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хорооны Иргэдийн нийтийн хурлаар батлуулж, биелэлт, үр дүнг тооцон, хагас жил тутам гишүүн, оршин суугчдад ажлаа тайлагнана.

8.8. Иргэд, оршин суугчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.

8.9. “Хөршийн хяналтын бүлэг” нь хорооны нутаг дэвсгэрт хамаарах нийтийг хамарсан арга хэмжээнд оролцож ажиллана.

8.10. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран нийтийн болон урамшилт эргүүлийг зохион байгуулах

8.11. Гэмт хэрэг, зөрчил болон бусад зөрчил, дутагдлын талаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл хүлээн авах, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, биелэлтийг хянах тогтолцоог бүрдүүлж ажиллана.

8.12. Амьдрах орчны эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм сахиулах, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байлгах, зөрчлийг таслан зогсооход дэмжлэг үзүүлнэ.

8.13. Иргэд, оршин суугчдыг хууль, эрх зүйн мэдээ, мэдээллээр тогтмол хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга, яриа таниулга хийж, санамж сэрэмжлүүлэг тараана.

8.14. Бүлэг нь иргэд, оршин суугч, бүлгийн гишүүдээс ирүүлсэн мэдээллийн нууцлалыг хамгаална.

## Ес. Бүлгийн гишүүдийн эрх, үүрэг

9.1. Иргэд, оршин суугчид өөрсдийн оршин суугаа орц, байр, гудамжаараа эвлэлдэн нэгдэж, сайн дурын үндсэн дээр iХөршийн хяналтын бүлэг-т гишүүнээр элсэнэ.

9.2. Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, нийтийн хэв журмыг гажуудуулахгүй байж, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд сахина.

9.3. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудад шуурхай дамжуулж иргэний үүргээ биелүүлнэ.

9.4. Нийтийн хэв журам сахихыг бусад оршин суугчдаас шаардах, бусад оршин суугчдын саналыг хүлээн авах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ.

9.5. Гэмт халдлагаас өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэнд, өмчийг хуулийн хүрээнд хамгаалах арга хэмжээ авна.

9.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд идэвхи, санаачлагатай оролцоно.

9.7. Гэр, орон байраа удаан хугацаагаар эзэнгүй орхих, бусад туслалцаа шаардлагатай тохиолдолд iХөршийн хяналтын бүлэг-ийн гишүүдэд мэдэгдэн дэмжлэг, туслалцаа авна.

9.8. Амьдрах орчны эрүүл ахуй, ариун цэврийг сайжруулах, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх талаар бусдад шаардлага тавина.

Арав. Нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөлийн эрх, үүрэг

10.1. Нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл нь холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг “Хөршийн хяналтын бүлэг”-ийн хэлбэрээр хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

10.2. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ажиллах чиглэлийг тодорхойлно.

10.3. Харьяа холбогдох байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжийг iХөршийн хяналтын бүлэгг-ийн үйл ажиллагаанд татан оролцуулна.

10.4. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжих, чадавхижуулах, сурталчлах, мэдээлэх, сургалт явуулах арга хэмжээ зохион байгуулна.

10.5. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжих, гишүүдийг чадавхижуулах, сурталчлах, мэдээлэл, сургалт явуулах, урамшуулах зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Арван нэг. Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг

11.1. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг, үзүүлж хамтран ажиллана.

11.2. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар iХөршийн хяналтын бүлэгг-ийн гишүүдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шуурхай шалгаж шийдвэрлэн хариу мэдэгдэнэ.

11.3. Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, амьтан, эд зүйлийн талаар бүлгийн ахлагчийг мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

Арван хоёр. Сууц өмчлөгчдийн холбооны эрх, үүрэг

12.1. Өөрийн холбоонд харьяалалтай байр, орон сууц, гудамжны айл өрх, иргэдийн амар тайван, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хорооны иргэдийн нийтийн хурал, цагдаагийн байгууллага, “Хөршийн хяналтын бүлэг”, оршин суугч иргэдтэй хамтран ажиллана.

12.2. Сууц өмчлөгчдийн холбооноос харьяалсан нутаг дэвсгэр, аж ахуйн нэгж, гудамж, талбай, орон сууцанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

12.3. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны мэдэгдэл,

шаардлага, зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч, хариуг хугацаанд нь өгөх.

12.4. “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

Арван гурав. Шагнал, урамшуулал

13.1. “Хөршийн хяналтын бүлэг”, түүний гишүүд болон үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулсан, дэмжиж ажилласан байгууллага, албан тушаалтныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хэлбэрээр урамшуулна.

13.2. Идэвхисанаачлага, үр дүнтэй ажилласан бүлгийн ахлагч, гишүүн, иргэдийг гадаад, дотоодын туршлага судлах уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцуулна.

13.3. “Хөршийн хяналтын бүлэг”, түүний гишүүдийг тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс урамшуулж болно.

Арван дөрөв. Ажлын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт:

14.1. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хор хохирол учирсан болон учирч болзошгүй тохиолдлын мэдээллийг холбогдох байгууллагад цаг алдалгүй холбон зуучилж, мэдээлсэн;

14.2. Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр идэвхи, зүтгэлтэй ажилласан;

14.3. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад тогтмол өгч ажилласан;

14.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхи, зүтгэл гарган ажиллаж иргэдийн талархлыг хүлээсэн;

14.5. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран үр дүнд хүрсэн ажил зохион байгуулсан;

14.6. “Хөршийн хяналтын хөтөлбөр”-ийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг харгалзан үзнэ;



Арван тав. Хориглох зүйл.

15.1. Иргэд, оршин суугч, бүлгийн гишүүд холбогдох байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан дарамт үзүүлэх, ажлын зохиомол ачаалал үүсгэхийг хориглоно

15.2. Бүлгийн үйл ажиллагаатай холбогдуулан олж авсан мэдээ, мэдээллийн нууцлалыг задруулахыг хориглоно.

Арван зургаа. Хүлээлгэх хариуцлага

16.1. Хөршийн холбооны бүлгийн гишүүд эрх мэдлээ хэтрүүлэн хууль тогтоомж, журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

## ИТГЭЛЦЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Жич:Энэхүү гэрээний загварыг хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан өөрчилж болно.

20 \_\_ он \_\_ сар \_\_ өдөр

Улаанбаатар хот

Нэг: Нийтлэг үндэслэл

Нийслэлийн нутаг дэвсгэр, гудамж талбай, байр, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвх, санаачилгад суурилсан амгалан тайван байдлын тогтолцоог бүрдүүлэх зорилготой Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт хөтөлбөр”, “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэргэжүүлэх ажлын хүрээнд “Хөршийн хяналтын бүлэг”, Сууц өмчлөгчдийн холбоо, хорооны Засаг дарга, Хэсгийн байцаагч нарын итгэлцэн хамтран ажиллах үйл ажиллагааг зохицуулна.

Хоёр: Гэрээ байгуулах талууд

Жишээ нь:

2.1 Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны Засаг дарга Ц.Дорж

2.2 Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Д.Болд

2.3 5 дугаар байрны 1 дүгээр орцны “Сонор” “Хөршийн хяналтын бүлэг”-ийн ахлагч Б.Дамба, и-мэйл хаяг \_\_\_\_\_ нууц үг \_\_\_\_\_

2.3 “Итгэл” Сууц өмчлөгчдийн холбооны захирал Б.Цэнд нар итгэлцлийн үндсэн дээр харилцан, хамтран ажиллах энэхүү гэрээг байгуулав.

Гурав: “Хөршийн хяналтын бүлэг”-ийн эрх, үүрэг

3.1 Гишүүд, оршин суугч иргэдтэй уулзалт зохион байгуулж, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэл баримталах.

3.2 Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчтай тогтмол уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцон хамтарч ажиллах.

3.3 Хорооны Засаг дарга, Сууц өмчлөгчдийн холбоо хороо хариуцсан хэсгийн байцаагч, оршин суугчидтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдлээс хамгаалах, хууль бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр ажиллах.

3.4 Бүлгийн гишүүдийн утасны жагсаалтыг гаргаж, гишүүдэд анхааруулах, мэдээлэл түгээх сүлжээг бий болгож, холбогдох байгууллага /цагдаа, онцгой байдал, эмнэлэг/-ыг мэдээ, мэдээллээр шуурхай хангах.

3.5 Болзошгүй гамшиг, осол, эрсдэлийн үед хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, гишүүдэд сургалт зохион байгуулж, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх.

3.6 Хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хорооны Иргэдийн нийтийн хурлаар батлуулж, биелэлт, үр дүнг тооцон, хагас жил тутам гишүүн, оршин суугчдад ажлаа тайлагнах.

3.7 Иргэд, оршин суугчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах.

3.8 Гэмт хэрэг, зөрчил болон бусад зөрчил, дутагдлын талаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл хүлээн авах, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, биелэлтийг хянах тогтолцоог бүрдүүлж ажиллах.

3.9 Иргэд, оршин суугчдыг хууль, эрх зүйн мэдээ, мэдээллээр тогтмол хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга, яриа таниулга хийж, санамж сэрэмжлүүлэг тараах.

3.10 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн гишүүдийн мэдээ, мэдээлэл дамжуулах сүлжээ бүхий [www.ubneighbourhood.mn](http://www.ubneighbourhood.mn) цахим хуудас, ухаалаг гар утас /iOS, Андроид/-нд зориулсан iPolice аппликейшн-г ашиглан цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах

3.11 Бүлэг нь иргэд, оршин суугч, бүлгийн гишүүдээс ирүүлсэн мэдээллийн нууцлалыг хамгаалах.

Дөрөв: Хорооны Засаг даргын эрх, үүрэг

4.1 Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, дүүргийн Засаг даргын тамгын газар, хорооны иргэдийн нийтийн хурал, хороо хариуцсан хэсгийн байцаагч, Сууц өмчлөгчдийн холбоо зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

4.2 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ажиллах чиглэлийг тодорхойлох.

4.3 Харьяа холбогдох байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжийг “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд татан оролцуулах.

4.4 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжих, чадавхижуулах, сурталчлах, мэдээлэх, сургалт явуулах арга хэмжээ зохион байгуулах.

4.5 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжих, гишүүдийг чадавхижуулах, сурталчлах, мэдээлэл, сургалт явуулах, урамшуулах зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг холбогдох газруудаар шийдвэрлүүлэх.

4.6 Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гудамж, орон сууцны орц, нийтийн эзэмшлийн талбайг орон нутгийн төсвийн хөрөнгөөр камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Тав: Хэсгийн байцаагчийн эрх, үүрэг

5.1 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг, үзүүлж хамтран ажиллах.

5.2 Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар Хөршийн хяналтын бүлэг-ийн гишүүдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шуурхай шалгаж шийдвэрлэн хариу мэдэгдэх.

5.3 Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлагдаж байгаа

хүн, мал, амьтан, эд зүйлийн талаар бүлгийн ахлагчийг мэдээ, мэдээллээр шуурхай хангах.

Зургаа: Сууц өмчлөгчдийн холбооны эрх, үүрэг

6.1 Өөрийн холбоонд харьяалалтай байр, орон сууц, гудамжны айл өрх, иргэдийн амар тайван, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хорооны иргэдийн нийтийн хурал, цагдаагийн байгууллага, “Хөршийн хяналтын бүлэг”, оршин суугч иргэдтэй хамтран ажиллах.

6.2 Сууц өмчлөгчдийн холбооноос харьяалсан нутаг дэвсгэр, аж ахуйн нэгж, гудамж, талбай, орон сууцанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

6.3 “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллах.

Долоо: Гэрээг дүгнэх

7.1 Хийсэн ажлаа хагас бүтэн жилээр иргэд оршин суугчдад тайлагнана.

7.2 Хийсэн ажлын тайланг харгалзан хорооны иргэдийн нийтийн хурлаар гэрээг дүгнэнэ.

7.3 Гэрээний үүргээ сайн биелүүлсэн “Хөршийн хяналтын бүлэг”, Сууц өмчлөгчдийн холбоо, хорооны Засаг дарга, Хэсгийн байцаагч нарыг тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс урамшуулж болно.

Найм: Хариуцлага

8.1 Хөршийн холбооны бүлгийн гишүүд эрх мэдлээ хэтрүүлэн хууль тогтоомж, журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

## Ес: Хяналт тавих

9.1 Нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, хорооны иргэдийн нийтийн хурал нь гэрээний биелэлтэнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ажиллах чиглэлийг тодорхойлно.

## ИТГЭЛЦЛИЙН ГЭРЭЭГ БАТАЛГААЖУУЛСАН:

_____	Хэсгийн байцаагч, _____	_____	_____
дүүргийн ___-р	цагдаагийн	Хөршийн хяналтын	СӨХ-ны захирал
хорооны Засаг	_____	бүлгийн ахлагч	_____
дарга	_____	_____	_____

## “ХӨРШИЙН ХЯНАЛТЫН БҮЛЭГ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АШИГЛАХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ

*Хөршийн хяналтын бүлэг гэдэг нь:* Иргэн бүр өөрсдийн амьдарч буй орчин, эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дураар цагдаагийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах иргэдийн эв нэгдэл юм.

*Ач холбогдол нь:* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оршин суугчид, иргэний нийгмийн байгууллагууд тэр дундаа Сууц өмчлөгчдийн холбоодын хүч дэмжлэгийг авах, нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх төдийгүй гэр, ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох,

Иргэдийн оролцоо эрх бүхий байгууллага, албан тушаалтны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа нэгтгэн зохион байгуулж ахуйн хүрээнд үйлдэгдэж буй хууль бус үйлдлүүдийг саармагжуулах, бууруулах чиглэлд ахиц гаргах явдал юм.

Иймд та бүхэнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Үүнд:

1. Үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм журмыг судлан иргэдэд сурталчлан таниулах.

2. Иргэд сайн дурын үндсэн дээр орц, байр, гудамж, хэсэг, хотхоноороо зорилгоо нэгтгэж “Хөршийн хяналтын бүлэг” байгуулна.

3. “Хөршийн хяналтын бүлэг” нь хэдэн ч гишүүнтэй байж болох бөгөөд гишүүдийн тоог нэмэгдүүлэх бодлого барина.

4. Гишүүдийн хурлаар бүлгийн ахлагчийг сонгоно.

5. “Хөршийн хяналтын бүлэг”-н ахлагч нь төлөөлөн харилцан итгэлцлийн үндсэн дээр тулгуурлан, сууц өмчлөгчдийн холбоо, засаг дарга, хэсгийн байцаагч нартай итгэлцлийн гэрээ байгуулж, хамтран ажиллана.

6. Хариуцсан байр, орц, гэр хорооллын Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдэлийн үнэлгээ,

судалгааг цагдаагийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллага СӨХ-той хамтарч хийн цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлно./ иргэд амьдрахад аюул учруулж болохуйц гаднын хүчин зүйлүүд тухайлбал золбин нохой, хог хаягдал, халтиргаа, гулгаа, гуу жалга, гэрэлтүүлэг, камергүй орчин, бүлэг бөөгнөрөл үүсдэг архичид цугладаг цэг, хууль дүрэм зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд гэх мэт/

7. Эрсдэлийн үнэлгээ, судалгааг үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гарган хорооны Иргэдийн нийтийн хурлаар батлуулна.

8. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцон, хагас жил тутам хариуцсан хэсгийн гишүүн, оршин суугчдад ажлаа тайлагнана.

9. Нутаг дэвсгэр хариуцсан хорооны Засаг дарга, СӨХ, цагдаагийн байгууллага, алба хаагч, оршин суугч иргэдтэй тогтмол уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцож, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг, чадавхжуулах, сурталчлах, ажлыг зохион байгуулна.

6. Иргэд, оршин суугчдын сайн дурын идэвхи санаачлага, итгэлцэлд түшиглэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, хувь хүний нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллана.

7. Бусад дүүрэг хороодын сайн ажиллаж байгаа “Хөршийн хяналтын бүлэг”-үүдийн туршлагыг судалж, үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.

8. Гэр хороолол, орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орц хонгилд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд буюу хорооны хэсгийн байцаагчид шуурхай мэдэгдэнэ.

9. Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оршин суугчдын дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулна.



10. Хөршийн хяналтын бүлгийн гишүүдийг бүртгэх, холбох, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зориулалт бүхий [www.ub-neighbourhood.mn](http://www.ub-neighbourhood.mn) цахим хуудас, иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг фото зураг, видео бичлэг, текстэн хэлбэрээр хүлээн авах iPolice ухаалаг гар утас /iOS, Андроид/-нд зориулсан аппликейшнийг үйл ажиллагаандаа ашиглана.

11. “Хөршийн хяналтын бүлэг” нь тухайн хорооныхоо нутаг дэвсгэрт хамаарах нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхтэй оролцож, нийтийн болон урамшилт эргүүлийг зохион байгуулна.

12. “Хөршийн хяналтын бүлэг”-н ахлагч хорооны Засаг дарга, хэсгийн байцаагчтай хамтран гишүүд, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмчийг хуулийн хүрээнд хамгаалах арга хэмжээг авч ажиллана уу

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Айл хүний амь нэг

Саахалт айлын санаа нэг

## ХӨРШИЙН ХЯНАЛТ” НЭГДСЭН СИСТЕМ


www.neighbourhood.mn

Хөршийн хяналтын нэгдсэн систем нь цахим хуудас / www.neighbourhood.mn/, ухаалаг гар утсан зориулсан iPolice аппликейшнээс бүрдэнэ.



### Цахим хуудас

Цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хөршийн хяналттай холбоотой мэдээ мэдээлэл /видео, фото/, холбогдох хууль тогтоомж, тогтоол, журам, хөтөлбөр, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэнэ.



Цахим хуудас нь:

- Мэдээ мэдээлэл хүргэх
- Бүлгийн гишүүдийг бүртгэх /гишүүд нэвтрэх/ гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.


Цахим хуудасны цэсний бүтэц

- Бидний тухай
- Мэдээлэл
- Хууль, тогтоомж
- Тусламж
- Холбоо барих
- Нэвтрэх хэсэг

“Доош заасан сум” дээр дарахад төслийн танилцуулга, видео мэдээ, хөршийн бүлэг гишүүдийн статистик үзүүлэлт болон мэдээлэл харагдана.

Бүлгийн гишүүдийг бүртгэх, цахим гэрээ байгуулах:

Хорооны ажилтан, хэсгийн байцаагч шинээр байгуулагдсан бүлгийг бүртгэж, цахим гэрээ байгуулна. Цахим гэрээг байгуулахдаа бүлгийн гишүүдийн овог нэр, и-мэйл хаяг, утасны дугаараар бүртгэж, бүлгийн ахлагч, гишүүдэд системд нэвтрэх эрх, нууц үгийг олгоно.



Хорооны ажилтан,

хэсгийн байцаагч өөрийн эрхээр системд нэвтэрч орсноор:

- Мэдээ мэдээлэл харах
- Бүлэг, бүлгийн гишүүдийг шинээр бүртгэх, засах, устгах
- Цахим гэрээ байгуулах
- Хувийн мэдээллээ засах
- Гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад өгөх

Бүлгийн гишүүд өөрийн эрхээр системд нэвтэрч орсноор:

- Мэдээ мэдээлэл харах
- Бүлгийн гишүүд болон нэгдсэн бусад бүлгийн гишүүдтэй харилцах
- Хувийн мэдээллээ оруулах, засах
- Гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол мэдээлэл цагдаагийн байгууллагад өгөх эрхтэй.
- Сонирхол, ажил мэргэжил бусад зүйлээр олон нийтийн

бүлэг үүсгэх,  
харилцах

Бүлгийн гишүүд  
нууц үгээ мартсан  
тохиолдолд өөрийн  
бүртгүүлсэн е-мэйл  
хаягийг ашиглаж  
сэргээнэ.



### iPolice ухаалаг гар утасны програм

Ухаалаг гар утсанд зориулсан програмаар дамжуулан хөршийн хяналт цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээллийг харах, бүлгийн гишүүд өөрийн эрхээр нэвтрэх, иргэд гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр цагдаагийн ирүүлнэ.



iPolice програм:

- Хөршийн хяналтын цахим хуудас
- Зөрчил мэдээлэх
- Нэвтрэх хэсэг гэсэн 3 үндсэн хэсэгтэй.

Хөршийн хяналтын цахим хуудас:

Энэ хэсэгт нэвтэрснээр цахим хуудсанд нийтлэгдсэн хөршийн хяналттай холбоотой мэдээ мэдээлэл /видео, фото/, холбогдох хууль тогтоомж, тогтоол, журам, хөтөлбөр, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг хүлээн авна.

Зөрчил мэдээлэх: Бүлгийн гишүүд өөрийн эрхээр, иргэд овог, нэр е-мэйл хаягаараа бүртгүүлэн гэмт хэрэг зөрчлийн талаар гомдол, мэдээлэл өгнө.

Нэвтрэх хэсэгт бүлгийн гишүүд өөрийн эрхээр нэвтрэн орж цахим хуудастай ижилхэн үйлдлүүдийг хийх, иргэд бүртгүүлсэн эрхээрээ нэвтрэн орж цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явц үр дүнгийн талаарх мэдээллийг харах боломжтой.



УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР